

## **«БНМАУ, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСАГ БА СОЁЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР» БАЙГУУЛАГДСАНААС ХОЙШИХ ХЯТАД АЖИЛЧДЫН КЛУБУУДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

*Цэрэнтулгын Түмэнбаяр  
Монголын Зохиолчдын эвлэл, магистр  
Email: [tumenbayartserentulga@gmail.com](mailto:tumenbayartserentulga@gmail.com)*

**Хураангуй:** «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулагдсанаас хойших Хятад ажилчдын клубуудийн үйл ажиллагаа 1952-1966 оны хооронд улам эрчимжиж, эртнээс суурьшсан хятад иргэд болон БНМАУ-ын шинэ хөгжлийн бүтээн байгуулалтад оролцохоор Хятадаас ирсэн ажилчдыг гэгээрүүлэн боловсруулах ажлаа тасралтгүй үр дүнтэй гүйцэтгэсэн билээ. Энэ талаар олон эх сурвалж дээр үндэслэн бичиж дүгнэлт гаргалаа.

Хэдийгээр 1966 онд үйл ажиллагаа нь бүрмөсөн хаагдсан ч 1925 оноос хойш 41 жилийн туршид Монголд ажиллаж байсан Хятад ажилчдын арваад клубийн үйл ажиллагааны түүх нь тухайн үед гүйцэтгэж байсан соёл урлаг, хүмүүжлийн болон хүмүүнлэгийн ажлын талаасаа ч тус хоёр улсын 1949-1964 он хүртэлх хамтын ажиллагааг гүнзгийрэхэд, 1991 оноос Монгол-Хятадын харилцаанд эерэг уур амьсгал бүрдэх, олон талт хамтын ажиллагаа сэргэхэд таатай нөлөө үзүүлсэн хэмээн дүгнэж байна.

**Түлхүүр үг:** Хятад ажилчны клуб, Үйлдвэрчний эвлэл, Ший-Яньз, бичиг үсэг, соёл урлаг.

«БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулагдсанаас хойших Хятад ажилчдын клубуудийн үйл ажиллагаа 1952-1966 оны хооронд улам эрчимжиж, эртнээс суурьшиж ирсэн хятад иргэд болон БНМАУ-ын шинэ хөгжлийн бүтээн байгуулалтад оролцохоор Хятад улсаас ирсэн ажилчдыг гэгээрүүлэн боловсруулах ажлаа тасралтгүй үр дүнтэй гүйцэтгэсэн билээ. Энэ талаар Монгол Улсын Үндэсний төв архив, Нийслэлийн архивын газрын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримт материал, Монгол Улсын театрын музей, Улаанбаатар хотын музейн үзмэрийн сан хөмрөгөөс гадна гадаадын жуулчин, монгол, хятад судлаачдын монгол хэлээр бичсэн ном товхимол, сонин сэтгүүл, Нийслэл Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн хятад ажилчны клубуудад ажиллаж байсан хүмүүсийн дурсамжийг үндэслэн бэсрэг өгүүлэл бичихийг хичээлээ.

Өгүүлэн буй хугацаанд ажиллаж байсан Хятад ажилчдын клуб нь хоёр улс дипломат харилцаа тогтоохоос 30-аад жилийн өмнө байгуулагдсан түүхийг сөхөхгүйгээр энэ тухай бичих аргагүй юм.

"Анх Их Хүрээ 1778 онд одоогийн Сэлбэ голын эрэгт нүүдэллэн ирэхэд Маймаа хотын дэвсгэр дээр 12 майхантай хятад худалдаачин ирж суурилан, мөн хятад худалдаачдаас 72 хятад хүн бараа таваар дамнаж Хүрээнд авчран худалдаа наймаа хийдэг байсан учир баруун, зүүн дамнуурчныг Манжийн үед Хүрээний 72 дамнуурчин пүүс"<sup>1</sup> гэж нэрлэсэн ажээ. "Хятадын харьяат ба худалдаачны суух есөн гудамж буюу баруун, зүүн дамнуурчин, Маймаа хот хэмээгч бол мөн манж, хятадын хөрөнгөтөн худалдаачин"<sup>2</sup>... суурьшсан газар байжээ. /Зураг 1/



Зураг 1. Баруун дамнуурчин буюу 9 гудамж

Мөн 1919-1920 оны үед Монгол орноор жуулчилж явсан Оросын жуулчин Майскийн тэмдэглэлд дурдсанаар "Автономит Монгол Улсад 542 мянган монголчуудаас гадна ноёд, түшмэл, цэргийн эрхтэн дархтан, жүжигчид, эмч, багш нарын зэрэг мэргэжилтэй, мэргэжилгүй 100 мянга орчим хятад иргэд оршин сууж байжээ. Хятадуудын дийлэнх нь 15-50 насныхан<sup>3</sup>..." бөгөөд тэд "... Өргөө, Хиагт, Улиастай, Ховдын хязгаарт хятад хороолол, гудамж байгуулан бөөгнөрөн суурьшиж, газар тариалан, жижиг уурхай, гар урлалын жижиг үйлдвэрлэл, улирлын чанартай ажил эрхлэхээс гадна ихэнх нь дэн буудал, хоолны газарт ажиллаж, Монгол нутаг даяар арилжаа наймаа хийдэг ... худалдаачид байжээ"<sup>4</sup>.

<sup>1</sup> МУЗГХЭГ, Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис, Адмон ХХК. УБ., 2011. т.196

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> И.М.Майский, Монгол орон хувьсгалын босгон дээр. УБ., 2015. 29,79-р хуудас

<sup>4</sup> Ч.Дашдаваа, Ч.Болд, Жоу Энлай ба Монгол орон, УБ., 2014. 28-р хуудас

БНМАУ-ын анхдугаар их хурлаас *"Гадаадын хүмүүсийг ялган салгаж, шударга түвшнийг нь батлан хамгаалах... нэмэн ирэхийг хэмжээлэх... харьяат яамнаас даруй нарийн чанга дүрэм хэмжээ тогтоож зохих газар батлуулан зарлаж дагаж шийтгэвэл зохих"*<sup>5</sup> тухай хэлэлцжээ. 1925 онд хуралдсан БНМАУ-ын II их хурлын баримт бичигт: *"Тус улсын нутаг дэвсгэрт Хятадын харьяат 28118 иргэн байна. Хятад улстай найрамдлын гэрээ, хэлэлцээргүй тул хил хязгаараар нэвтрүүлэхийг зогсоох, урд ирэгсдийг ялган салгах, тус оронд суугаа гадаадын хүмүүсийг тодорхойлох зэрэг асуудал"*<sup>6</sup> тулгарч байсан тухай бичсэн байна.

Тиймээс Монголын нутаг дэвсгэр дээр суурьшиж үлдсэн хятад иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний оюун санаа, соёлын хэрэгцээг хангах шаардлага урган гарч, энэ шаардлагыг хангахад Монголын үйлдвэрчний эвлэл чухал үүрэг гүйцэтгэсэн нь баримтаар нотлогдож байна. Тэгээд ч Нийслэл Хүрээ дэх оросуудын байгуулсан «Олон ястны үйлдвэрчний эвлэл» хэмээх байгууллага нь орос, монгол, хятад, төвөд, буриад ажилчдыг эгнээндээ нэгтгэн үйл ажиллагаагаа өргөжүүлээд эхэлчихсэн байжээ.<sup>7</sup>

Хятадын ший жүжиг тоглодог гол төв нь 1919 оны үед хятадын дөрвөн гудамжинд өмнө, хойт /На-Яньз, Ший-Яньз/ театр хэмээн нэрлэгдэж байгаад Монголын үйлдвэрчний эвлэлийн харьяанд 1930 оны үед ирсний дараа Өргөн чөлөөнд нүүж ирсэн байна. Өргөн чөлөө гэдэг нь Өргөөгийн баруун дамнуурчны гол гудамж буюу одоогийн Гандангийн зүүн доорх Бадма-Ёго дацан /хуучин Гэсэр сүм/-гаас Хүнсний нэгдүгээр дэлгүүр хүртэлх замыг хэлнэ.

Монголын үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн харьяа Хятад ажилчны клубийн тухай товч лавлах бичигт: *"Клубийг 1930 онд МАХН-ын Төв хороо, Засгийн газрын шийдвэрээр олон үндэстэн ястны дотор интернационалын соёл хүмүүжлийг дэлгэрүүлэх, ялангуяа зарц ядуу хятад ажилчдын боловсрол хүмүүжлийг дээшлүүлж аж амьдралыг сайжруулахад зориулж Төв зөвлөл эрхлэн улаан булангийн хэлбэрээр байгуулснаа 1932 онд клуб болгож, тэр үед оршин сууж байсан хятад мөлжимтгий худалдаачдын хувийн шийний газар орон байрыг хураан авч хятад ажилчдын соёлын хэрэгцээнд зориулан ...шилжүүлснийг Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөл, нам олон нийтийн байгууллагуудын 34000 төгрөгөөр санхүүжүүлэн засварлуулж ший жүжиг, кино тавих урлаг уран сайхны ажлыг явуулж эхэлсэн"* хэмээн тэмдэглэсэн байна.

Ший-Яньзыг эхэн үедээ Профинтерний\* нэрэмжит клуб хэмээн нэрлэж эрхлэгч, манаач хоёр л орон тоогоор ажиллуулж байсан ажээ. 1932 оны хавар тэрхүү улаан булангийн барилгыг засварлахгүйгээр ашиглаж үл болно гэсэн инженерийн акт гарсан учраас түр хааж,... Үйлдвэрчний эвлэлийн Төв

<sup>5</sup> БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, УБ., 1956. 8-р хуудас

<sup>6</sup> Нийслэлийн архив. Х-11, Д-01, ХН-3. Нугалбар-2.

<sup>7</sup> Б.Түдэв, БНМАУ-н ажилчин ангийн түүхээс 1921-1952, Түүхийн найруулал, ред- М.Санждорж, Улсын Хэвлэлийн Хороо, УБ., 1963. 25-р хуудас

зөвлөлөөс 9000, Намын төв хорооноос 5000 төгрөг өгснөөс гадна, 20000 төгрөгийг түр зээлдүүлэн өгч, барилгын иж бүрэн засвар, өргөтгөл хийжээ. Ингээд 1932 оны Октябрийн баяраар анхны киногоо гаргаж клубийнхээ нээлтээ хийсэн бөгөөд үүнээс хойш үйл ажиллагаа нь өргөжин тэлсэн байна. Сүүлд 1936 онд Монголын үйлдвэрчний эвлэлээс зээлдүүлсэн 20 мянган төгрөгөө тус клубт бүрмөсөн шилжүүлсэн аж. ... Тус Ший Яньз нь 1936 онд 100 гаруй хүний багтаамжтай улаан булантай болж, 12 хөгжимчин, 13 дуучин, 23 жүжигчин тус тус ажиллаж байснаас гадна, клубийн соёл хүмүүжлийн ажилд 120 хүн тогтмол оролцож байжээ<sup>8</sup>.

1935 онд Монголын үйлдвэрчний Төв зөвлөлийн тэргүүлэгчдийн VII хурлаас хятад ажилчдын дотор хүмүүжлийн ажлын чанарыг сайжруулах зорилгоор байгуулсан «Хятад ажилчны клуб»<sup>9</sup>-ын 4 дүгээр сард явуулсан эхний улирлын ажлын тайланг шалгасан тухай Үйлдвэрчний Төв зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэлд: *"Хятад ажилчны клуб нь нам засгийн тогтоол бодлого ба үйлдвэрчний эвлэлийн зорилтыг хятад ажилчид, олон нийтэд дэлгэрүүлэн таниулж олон түмний соёл боловсролын ажлыг хөгжүүлэн дээшлүүлэхэд туйлын чухал үүрэг гүйцэтгэсээр буй.."*<sup>10</sup> гэжээ.

Мөн хятад ажилчны клубийн дарга Эрэнцэнсономын илтгэлд: *"...ялангуяа ариун цагаан ажлаар биеийн хүчийг үнэлж амьдрагч хятад ажилчдын эрх ашгийг хамгаалж аж байдлыг сайжруулах зорилгоор...Улаанбаатар хот болон зарим аймгийн төвүүдэд «Хятад ажилчны клуб»-тэй болсны хамт хотод 4589 тооны ажилчинтай клуб нэг ба түүний гишүүн 1300 болж чадсан..."*<sup>11</sup> гэсэн байдаг.

Хятад ажилчдын клубууд нь БНМАУ-ын Үндсэн хуулийн хүрээнд батлагдсан дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж ирсэн байдаг. 1936 оны байдлаар Улаанбаатар хот, Налайх, Хэнтий, Сэлэнгэ, Ховд аймгуудад хятад ажилчны клубууд үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд Хятад ажилчдын клубийн ерөнхий бүтэц нь Улаанбаатар хотын «Хятад ажилчдын клубийн дагаж мөрдөх дүрэм»-ээс тодорхой харагддаг билээ. Эндээс үзэхэд урлаг, соёл, боловсрол, хүмүүжлийн гэсэн үндсэн таван чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Хятад ажилчдын клубийн дүрэмд зааснаас үзвэл: хятад ажилчдыг нэгдүгээрт: бичиг үсэг үл мэдэх явдлыг устгаж хятад болон орос, монгол хэл бичигтэй болгох, дөрвөн аргын тоо бодож сургах, хоёрдугаарт: «Зам»

\* Профинтерн нь Үйлдвэрчний эвлэлийн олон улсын нэгдсэн байгууллага юм. Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн үүсэхийн хамт Зөвлөлтийн үйлдвэрчний эвлэл болон Профинтернтэй харилцаа тогтоож хамтран ажиллах хүсэлтээ Бүх Монголын Үйлдвэрчний Эвлэлийн товчооноос 1926 оны 5 дугаар сард Профинтерний гүйцэтгэх товчоонд явуулж байжээ. Профинтерн Монголын үйлдвэрчний эвлэлийн хүсэлтийг идэвхитэй дэмжин харилцаа холбоогоо өргөтгөжээ./Зох/


<sup>8</sup> МУУТА, Х-535, ДН<sup>№</sup>1, ХН-2538, 23-25-р хуудас

<sup>9</sup> МУУТА, Х-535, ДН<sup>№</sup>1, ХН-7, 39-р хуудас

<sup>10</sup> МУУТА, Х-535, ДН<sup>№</sup>1, ХН-13, 49-50-р хуудас

<sup>11</sup> МУУТА, Х-535, ДН<sup>№</sup>1, ХН-7, 62-65-р хуудас

солиноор дамжуулан тэднийг гэгээрүүлэн боловсруулах, гуравдугаарт: улс төрийн боловсрол, хүмүүжлийн ажлыг зохион байгуулж, эв хамт шинэ нийгэмд төлөвшүүлэх, дөрөвдүгээрт: хятад ший жүжиг, киногоор үйлчлэх, тавдугаарт: бие бялдрын хүмүүжил олгох зэрэг үйл ажиллагааг идэвхтэй явуулж, тогтсон хугацаанд Монголын үйлдвэрчний эвлэлд тайлагнан, үр дүнг хэлэлцэж, түүний үндсэн дээр тодорхой зорилтуудыг тавьж ажилласан байна. /Зураг 2/



Зураг 2. Төв аймагт Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлөөс хятад ажилчдыг бичиг үсэгт сургах тухай. Х535-Д01-ХН2538

Монголын үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн дэргэдэх хятад ажилчдын тасгаас 26 /1936/ оны 1 дүгээр сарын 2-ны МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга, тэргүүлэгч нарт Хятад ажилчны дунд явуулах сурган хүмүүжүүлэх ба олон нийтийн ажлын тухай илтгэлд дурдсанаас үзэхэд: Хятад ажилчдын клуб нь "...Орос бичгийн хичээл долоо хоног тутам 3 удаа тус бүр 2 цагийн хичээл 11-15 хүртэл ажилчин явмой. Үүнд дан ганц орос бичиг заамой. Монгол бичгийн хичээл 7 хоногт 2 удаа тус бүр 2 цагийн хичээл 12-15 хүртэл ажилчин явмой... Хятад бичгийн хичээлийг 7 хоногт нэг удаа явмой. 5-10 хүртэл тооны ажилчин үргэлжлэн явмой. Тоо бодлогын хичээл 7 хоногт 1 удаа явмой. 8-10 хүртэл хүмүүс явмой. Дан ганц тоо бодлого заамой"<sup>12</sup> гэснээс үзэхэд

<sup>12</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2522, 125-р хуудас

юуны өмнө насанд хүрэгсдийг ажлыг нь алдагдуулахгүйгээр бичиг үсэгтэй болгох зорилгоор ажлын бус цагаар идэвхтэй зохион байгуулж байсан нь харагдаж байна.

...Мөн хятад клубийн удирдлагын доор байгуулсан хятад хүүхдийн сайн дурын сургууль нэгийг байгуулсан бөгөөд тус сургуульд бүгд 34 хүүхэд сурдаг. Эдгээр цөм хятад эцэгтэй бөгөөд монгол, орос эхээс төрсөн хүүхдүүд аж. Тэд 7-15 хүртэл настай. Энэ хүүхдийн сургууль нь клубийн удирдлагын дор ажлаа явуулдаг бөгөөд өглөөний есөн цагаас эхлэн оройн дөрвөн цаг хүртэл өдөр тутам зургаан цаг хичээллэдэг. Орос бичиг 2 цаг, монгол бичиг 2 цаг, хятад бичиг 2 цаг тогтмол орж байсан аж. Хагас цагт дуу ба биеийн тамирын хичээл, хагас сайн өдөр /Бямба гараг/ 2 цаг тусгай зураг зуруулдаг байжээ. Энэхүү сургуулийн хүүхдийн хоол, унд, бичгийн хэрэглэл болон багш нарын цалин хөлсийг бүрнээ клубээс гаргадаг байсан<sup>13</sup> тухай архивын баримтад өгүүлсэн байна.

Дорнод, Ховд, Завхан, Архангай, Сэлэнгэ, Хэнтий зэрэг зарим аймгуудад тус бүр хятад ажилчны клубууд буй бөгөөд эдгээр клубууд нь тус тусын аймгийн Үйлдвэрчний эвлэлийн товчооны удирдлагын дор ажиллаж байснаас гадна тус бүрд тусгай орон тооны ажилчидтай бөгөөд эдгээр орон тооны хүмүүс нь хятад ажилчдын эрх ашгийг хамгаалах, бичиг үсэгт сургах, ший жүжиг гаргаж, уншлага, тайлбар яриа явуулах зэрэг ажлуудыг эрхэлдэг байсан байна.<sup>14</sup>

Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Д.Лувсаншарав 2003 оны 3 дугаар сард бичсэн хөгжмийн зохиолч Д.Бадарчийн тухай "Нөхрийн тухай товч" хэмээх дурсамждаа:

*"Өнгөрсөн зууны 40-өөд онд манай Хэнтий аймгийн төвд хятад ажилчдын клуб гэж байлаа. /хожим нь Хэнтийн «Ягаан клуб» гэж нэршсэн/ энэ клубийн барилгыг манай аймгийн төвд суурьшсан хятад голдуу ажилчид өөрсдийн сайн дурын санаачилга хөрөнгөөр 1940 онд барьж байгуулж тэр үедээ л соёл урлаг, олон нийтийн төв болон бужигнаж байв. Мэргэжлийн сургууль төгсөөгүй ч төв, хөдөө, гадааны авьяас билэг бүхий эрэгтэй, эмэгтэй залуус цугларч мандолин хөгжмөөс эхлэн үндэсний болон өрнийн хөгжим заалгах, мөн өөрсдийн санаачилга оролдлогоор суралцаж тэр үед ихэд тоглогдож байсан «Ардын зориг» /Хурц/ «Хөхөө», «Учиртай гурван толгой», «Дурданхүү», «Мандухай Сэцэн» зэрэг драмын болон хөгжимт жүжгээс гадна «Сайн дурын уран сайханчдад тусламж» гэдэг сэтгүүлд хэвлэгдсэн орчуулгын болон Монголын зохиолчдын зохиолууд жижиг үзэгдлүүд, шог хошин гараа зэргийг өөрсдийн хүчээр найруулан тоглож, дайны хүнд жилүүд боловч тэнд олон нийтийн бүжиг танц, кино гаргалт тасардаггүй байв." хэмээн өгүүлсэн байдаг.*

<sup>13</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2522, 126-127-р хуудас

<sup>14</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2522, 127-р хуудас

Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлөөс Хятад ажилчны төв клубийг БНХАУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын хүссэн ёсоор Монголд суугаа Хятад ажилчны зөвлөлд шилжүүлэн өгсөн болно хэмээх Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга Цэрэнпагма, Гэгээрлийн хэлтсийн дарга Ундрах нарын илтгэлд бичсэнээр: *“Засгаас авч явуулсан энэхүү арга хэмжээний үндсэн дээр Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн харьяа ажилчны клубууд бий болсон байна. Энэхүү хятадын худалдаачдын орон байшинг засварлуулж хятад ажилчдын соёлын төв болгоход зориулж үйлдвэрчний эвлэл болон нам, олон нийтийн байгууллагуудаас үзүүлсэн зүйл бүрийн тусламж ба хөрөнгө мөнгөний дээр хятад ажилчид өөрсдийнхөө сайн дураар хөрөнгө нэмэрлэх ба субботник зарлаж клубүүдийг байгуулсан байна. Үүнээс эхлэн хятад ажилчдын сайн дурын үндсэн дээр тэдний дотор дуу, бүжиг, хөгжим жүжгийн бүлгэмүүдийг зохион байгуулах ба ажилчдын дунд явуулах соёл гэгээрлийн ажлыг улам өргөтгөн явуулж ирсэн болно...”* хэмээн өгүүлсэн байдаг.

1955 оны 5 дугаар сард БНХАУ-аас БНМАУ-д туслах анхны 6000 ажилчин ирсэн<sup>15</sup> үеэс эхлэн хятад ажилчид ээлж ээлжээр ирж байсантай холбогдуулан тэдний эрх ашгийг хамгаалах, соёл боловсрол олгох ажлыг идэвхтэй явуулах шаардлага зайлшгүй гарч байсан ажээ. /Зураг 3/



Зураг 3. Хятад ажилчдын эхний ээлж. 1955 он

<sup>15</sup> Ч.Дашдаваа, Ч.Болд, Жоу Эньлай ба Монгол орон, УБ., 2014. 28-р хуудас

Иймд 1959 оны 3 дугаар сарын 27-нд БНХАУ-ын Элчин сайдын яамны зөвлөх Мин Ин, Гадаад яамны орлогч сайд Лхамсүрэнтэй уулзаж, Хятадын харьяат нарын зөвлөл Хятад ажилчны клуб, «Ажилчны зам» сонины газрыг БНМАУ-д буцаан шилжүүлэхийг хүсэж энэ талаар БНХАУ-ын Засгийн газрын ноотыг гардуулжээ.<sup>16</sup> Ингээд Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлд Хятад ажилчны клуб, «Ажилчны зам» сониныг 1959 оны 9 дүгээр сарын 5-нд шилжүүлэн өгсөн<sup>17</sup> байна.

1958 оны эцэс болон 1959 онд Монгол улсад 8200 гаруй хятад хүн ажиллаж байсны 5000 гаруй нь Улаанбаатар хотод, 3000 гаруй нь хөдөө орон нутагт ажиллаж байсан бөгөөд бүх ажилчдын 6000 гаруй нь барилгад, бусад нь өөр мэргэжлээр ажиллаж байжээ. 1958-1959 онд Хятад ажилчдын гэр бүлийн 11 мянга гаруй хүн байснаас тэдний 0.5% нь ажилтай, хятад ажилчдын 70% нь тогтмол ажилтай, 20% нь улирлын чанартай ажилтай байсан бөгөөд эдгээр ажилчид, тэдний гэр бүлийн дунд зохион байгуулах соёл хүмүүжлийн ажлыг тогтмол явуулах шаардлага урган гарсан байна.<sup>18</sup> Хятад ажилчдын клубийн дүрмийн дөрөвдүгээр бүлэгт зааснаар: Хятад ажилчдын клуб гол үйл ажиллагааныхаа чиглэлээр өөрийн гишүүд, ажилчдыг хүмүүжүүлэн боловсруулах зорилгоор тогтмол явуулж байваас зохих ажлуудыг гаргасан байна. Үүнд:

1. Тогтмол байнга олон нийтийн ажлын газрыг байгуулах
2. Улаан булан байгуулах ба түүний дотор үргэлжийн ажлыг зохиох
3. Нам засгийн ба Үйлдвэрчний эвлэлийн тогтоол бодлогыг үргэлжлэн таниулах ажлыг зохиох
4. Биеийн тамирын ажлыг зохиож явуулах
5. Хувьсгалын чанар бүхий танц бүжиг зэргийг байгуулж зохиох
6. Ший ба кино зургийг гаргах
7. Ханын сонин гаргах
8. Улс төр, тоо бодлого, монгол, орос, хятад хэл бичгийн зэрэг олон төрлийн бүлгэмүүдийг ажилчны сайн дурын дор байнга зохион байгуулах
9. Шатар, даам, бөмбөг зэрэг элдэв төрлийн тоглоомыг явуулах
10. Ажилчдын үр хүүхдийг сургаж хүмүүжүүлэхийн тулд сайн дурын сургуулийг байгуулж, түүний ажлыг чанаржуулах
11. Боловсролын сугалааг гаргах
12. Номын сан ба уншлагыг байгуулах эдгээр болмой гэсэн бөгөөд тус бүр бүлгэмд хуваарилагдан тогтмол цагаар хичээллэж байсан аж.

Залуу хятад ажилчид, гэр бүлийн хүмүүсийг бичигт сургахад нэг хүн 1500-гаас доошгүй ханз үсэг сурах, хятад ажилчид цөм монгол хэл сурсан байх зэрэг 13 төрлийн зорилт тавин ажиллах болжээ.

<sup>16</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2538, 1-2-р хуудас

<sup>17</sup> Мөн тэнд

<sup>18</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2552, 150-р хуудас

Мөн хийсэн ажлын тайланг улирал жилээр гаргаж, санхүүгийн орлого, зарлагыг нарийн бүртгэж, ажлын үр дүнг дүгнэж, түүний дагуу мөнгөн санхүү болон бусад ажлын талаар Үйлдвэрчний зөвлөл болон хятад ажилчдын тасгаас шалгалт явуулж байсан нь архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтуудаас тодорхой харагдаж байна. Ялангуяа бичиг үсэг үл мэдэх явдалтай тэмцэх, монгол, орос, хятад хэл бичиг сургах ажлыг эрчимтэй зохион байгуулж, хүн нэг бүрчлэн тогтмол шалгалт авч дүгнэдэг байжээ.<sup>19</sup>

Клуб нь хятад ажилчдын дотор сурган гэгээрүүлэх, суртал нэвтрүүлэг, радио нэвтрүүлэг, кино үзвэр зэрэг ажлуудыг зохион явуулдгаас гадна гэрэл зураг, оёдол, халуун ус, үсчин зэрэг туслах салбартай байжээ. БНХАУ-ын харьяат нарын нийгэмлэгийн зөвлөл, клуб, зам сонины бүх орон тоо 1959 оны байдлаар 95 байсан бөгөөд хүн тус бүр 200-1000 гаруй төгрөгийн цалин авч, үүнд жилд 460000 төгрөг зарцуулдаг байсан аж. Мөн жүжгийн хувцсыг БНХАУ-аас төхөөрч өгч байсан тухай ч дурдсан байдаг.

Хятад ажилчдын клуб нь биеэ даан өөрийн гишүүдийн хүчээр ажиллахаас гадна Монголын соёл урлагийн байгууллагууд, уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, харилцан туршлага солилцож байсан баримт цөөнгүй тохиолдож байна. Мөн ЗХУ-ын мэргэжилтэн, Хятадын нэртэй уран бүтээлчид ирж, багшилж байсны нэг тод жишээ нь БНХАУ-ын төрийн дууллыг зохиосон хөгжмийн зохиолч Сянь Шинхай юм. Гадаад яаманд байсан Шижээхүүгийн эхнэр Мааяа 1940-өөд онд Ший-Яньзад жүжигт тоглож байжээ.

Гэвч 1964 оноос хоёр улсын улс төрийн харилцаа “хүйтэрч”, 1966 оноос эхлэн хятад ажилчдыг эх орон руу нь ээлж дараагаар бүрмөсөн буцаах болсноор Улаанбаатарт болон аймаг орон нутагт ажиллаж байсан Хятад ажилчдын клубууд үйл ажиллагаагаа зогсоож, хаагдсан билээ.

Эцэст нь дүгнэн хэлэхэд:

-1925 онд сууриа тавьсан Хятад ажилчдын клуб нь 1949 онд БНХАУ тунхагласны дараа, 1952 онд “БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” байгуулагдсанаас хойш тус хоёр улсын хамтын ажиллагаа гүнзгийрэхэд, ялангуяа хятад ажилчдын оюуны хэрэгцээг хангахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзэж байна.

-Хэдийгээр 1966 онд үйл ажиллагаа нь бүрмөсөн хаагдсан ч 1925-аас 1966 он хүртэл 41 жилийн туршид Монголд ажиллаж байсан Хятад ажилчдын арваад клубийн үйл ажиллагааны түүх нь тухайн үед гүйцэтгэж байсан соёл урлаг, хүмүүжлийн болон хүмүүнлэгийн ажлын талаасаа ч 1991 оноос Монгол-Хятадын харилцаанд эерэг уур амьсгал бүрдэх, олон талт хамтын ажиллагаа сэргэхэд таатай нөлөө үзүүлсэн хэмээн дүгнэж байна.

<sup>19</sup> МУУТА, Х-535, Д-01, ХН-2538, 11-р хуудас

**Ашигласан материал:**

1. Ч.Алексей. Үйлдвэрчний Эвлэлийн хэвлэл, МҮЭТЗ., УБ., 1968
2. Д.Баасанжав. Хүрээ соёл, УБ., 2013
3. Д.Бадарч. Сэтгэлд шингэсэн дурсамж, УБ., 2003
4. БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, УБ., 1956
5. БНМАУ-ын түүх. Дэд боть, УБ., 1968
6. БНМАУ-ын Анхдугаар Их Хурал, УБ., 1984
7. Ч.Дашдаваа, Ч.Болд. Жоу Энълай ба Монгол орон. Монгол Улсын Архивын Ерөнхий газар, УБ., 2014
8. Д.Догсомжав. Монголын үйлдвэрчин. УБ.,
9. И.М.Майский. Орчин үеийн Монгол. УБ., 2005
10. Монгол улсын хүн ам XX зуунд. УБ., 1998
11. Монголын Үйлдвэрчний Эвлэлийн ажилтны лавлах V, УБ., 1969
12. Б.Түдэв. БНМАУ-ын ажилчин ангийн түүхээс 1921-1952. Түүхийн найруулал, ред- М.Санждорж, Улсын хэвлэлийн хороо, УБ., 1963
13. Чингэлтэй дүүргийн албан ёсны сайт. <http://www.chingeltei.gov.mn/archives/23001> 2019 оны 10 дугаар сар.
14. Үндэсний номын сангийн эрдэм шинжилгээний өгүүлэл, номууд
15. Х.Уянга. Хөгжмөө тоглоод суух нь түүнд жаргал байж. Ярилцлага. mongol news. 2011
16. Театрын музейн сан хөмрөг дэх гэрэл зургууд
17. Үндэсний төв архивын сан хөмрөг
18. Нийслэлийн архивын сан хөмрөг